**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 02 өдөр Дугаар А/49 Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Биеийн тамир, спортын хороонд ашиглагдаж буй RX-4020 Мөс цэвэрлэгч машины ашиглалт, засвар үйлчилгээ, аюулгүй ажиллагааны дүрмийг нэгдүгээр, RX-4020 Мөс цэвэрлэгч машины тосолгоо үйлчилгээний хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг мөсөн талбайн техникчид үүрэг болгосугай.

ДАРГА Р.ОЧИРПҮРЭВ

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН**
**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ**
**ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 02 өдөр Дугаар А/49 Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Биеийн тамир, спортын хороонд ашиглагдаж буй RX-4020 Мөс цэвэрлэгч машины ашиглалт, засвар үйлчилгээ, аюулгүй ажиллагааны дүрмийг нэгдүгээр, RX-4020 Мөс цэвэрлэгч машины тосолгоо үйлчилгээний хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг мөсөн талбайн техникчид үүрэг болгосугай.

ДАРГА Р.ОЧИРПҮРЭВ

Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/49 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

**RX-4020 Мөс цэвэрлэгч машины ашиглалт, засвар үйлчилгээ, аюулгүй ажиллагааны дүрэм**

Энэхүү дүрэм нь RX-4020 мөс цэвэрлэгч машиныг аюулгүй ажиллуулах, засвар үйлчилгээ хийхэд зориулагдсан. Машиныг зөвхөн /хоккейн болон гулгах талбайн мөс цэвэрлэхэд/ ашиглах бөгөөд бусад зориулалтаар хэрэглэх хориотой.

**АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА**

**1. Ажил эхлэхээс өмнө.**

1.2. Техникийн бүрэн бүтэн байдал (тоормос, гэрэл, дуут дохио, цахилгаан систем) шалгах

1.3. Мөсний зузаан, талбайн нөхцөл байдлыг үнэлэх. (хагарлын эрсдэл байгаа эсэхийг шалгах)

1.4. Хувийн хамгаалах хэрэгсэл өмсөх (ажлын бээлий, хальтардаггүй ултай гутал, чихний хамгаалалт)

1.5. Мөсөн талбайг бүрэн чөлөөлж талбайд нэвтрэх орц гарцыг бүрэн хаасны дараа цэвэрлэгээ эхэлнэ.

**2. Ажиллагааны үед.**

2.1. Мөс цэвэрлэх машиныг зөвхөн оператор ажиллуулна.

2.2. Машины хурдыг 5–10 км/ц-аас хэтрүүлэхгүй.

2.3. Мөс цэвэрлэх явцад мөсөн талбайд оператораас өөр хүн байхыг хориглоно. Зайлшгүй шаардлагатай бол машинаас 5 метрийн зайд байна.

2.4. Яаралтай зогсолт хийх хийх үед "Яаралтай зогсолт" товчийг дарж машиныг бүрэн зогсоож хөдөлгүүрийг унтраана.

2.5. **Цэвэрлэгээний дараалал.**

- Спираль дамжуулагчийг асаах
- Ирний гүнийг тохируулах /Цэвэрлэх гүн 2 мм-ээс хэтрэхгүй байх/
- Усны урсгалыг нээх
- Тогтмол хурдаар жигд цэвэрлэх

2.6. Мөс чэвэрлэж дууссаны дараа Хөдөлгүүрийг унтрааж, машиныг угааж техникийн үзлэг хийнэ.

2.7. Мөс цэвэрлэх машин цэнэглэхдээ дараах дарааллыг дагаж мөрдөнө.

- Машины үндсэн тогийг салгаж бүрэн унтраана.
- Үндсэн болон цэнэглэгчийн пускатлыг унтраасан байна.
- Цэнэглэгчийг машинд залгасны дараа үндсэн пускатл өгнө.
- Үндсэн Пускатл өгсний дараа цэнэглэгчийн пускатл өгнө.
- Үндсэн болон цэнэглэгчийн пускатл өгсний дараа СТАРТ ногоон товч дарж цэнэглэнэ
- Машин бүрэн цэнэглэгдэж дууссаны дараа СТОП улаан товч дарж цэнэглэх ажиллагааг дуусгана.

**Анхааруулга: Хэт их хурд нь спираль дамжуулагчийг бөглөх шалтгаан болдог**

**3. Хориотой үйлдлүүд**

3.1. Согтууруулах ундаа хэрэглэсэн, ядарсан үед ажиллах

3.2. Техникийн гэмтэлтэй машин ажиллуулах

3.3. Аюулгүй байдлыг шалгалгүй ажил эхлэх /1.3, 1.5-д заасан/

**ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

- ~~Хурд: 15 км/ц~~
- Цахилгаан хангамж: 72V / 15кВт
- Жин: 3500 кг (хоосон), 4285 кг (ачаалагдсан)
- Мөс цэвэрлэх өргөн: 1950 мм

**ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ**

**4. Өдөр тутмын шалгалт. Оператор нь машины эд ангид дараах шалгалтыг өдөр дутам хийнэ.**

4.1. Ирний (blade) хурц байдал, бэхэлгээг шалгах

4.2. Гидравлик систем дэх тосны түвшинг хянах

**5. Тогтмол засвар**

5.1. Ир солих: энгийн ирийг 25 цаг ажилласан бол. тусгай ган ирийг 60 цаг ажилласан бол солино.

5.2. Гидравлик тос солих: 2 сард нэг удаа шалгаж, 4 жил буюу 2000 цагт солино.

5.3. Тосолгоо үйлчилгээ, тохиргоог хавсралт №1-д заасан хугацаанд тогтмол хийж гүйцэтгэнэ.

5.4. Засвар үйлчилгээг зөвхөн техникч буюу мөс цэвэрлэгч машины оператор хариуцан хийнэ.

5.5. Оператор нь жил бүр хуваарьт засвар үйлчилгээтэй холбоотой зардал, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг гаргаж спорт хорооны дарга, нягтлан бодогчид танилцуулна. Гэнэтийн эвдрэл, гэмтэлтэй холбоотой зардлыг холбогдох албан тушаалтанд нэн дариу мэдэгдэж шийдвэрлүүлнэ.

**ГЭНЭТИЙН БУЮУ ЯАРАЛТАЙ НӨХЦӨЛД АВАХ АРГА ХЭМЖЭЭ**

6.1. Мөс хагарах: Машиныг тэр даруй зогсоож, бүх хүмүүсийг холдуулна.

6.2. Цахилгааны гэмтэл: Засвар хийхээс өмнө цахилгаан хангамжийг салгах

**ХАДГАЛАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТ**

7.1. Удаан хугацаагаар хадгалахдаа машиныг хуурай, сэрүүн орчинд байрлуулна.

7.2. Ир, цахилгаан хэсгүүдийг салгаж арчин даавуун материалаар боож хуурай газар хадгална

Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн ...А/49..... дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

**RX-4020 Мөс цэвэрлэгч машины ашиглалт, засвар үйлчилгээ, аюулгүй ажиллагааны дүрэм**

Энэхүү дүрэм нь RX-4020 мөс цэвэрлэгч машиныг аюулгүй ажиллуулах, засвар үйлчилгээ хийхэд зориулагдсан. Машиныг зөвхөн /хоккейн болон гулгах талбайн мөс цэвэрлэхэд/ ашиглах бөгөөд бусад зориулалтаар хэрэглэх хориотой.

**АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА**

**1. Ажил эхлэхээс өмнө.**

1.2. Техникийн бүрэн бүтэн байдал (тоормос, гэрэл, дуут дохио, цахилгаан систем) шалгах

1.3. Мөсний зузаан, талбайн нөхцөл байдлыг үнэлэх. (хагарлын эрсдэл байгаа эсэхийг шалгах)

1.4. Хувийн хамгаалах хэрэгсэл өмсөх (ажлын бээлий, хальтардаггүй ултай гутал, чихний хамгаалалт)

1.5. Мөсөн талбайг бүрэн чөлөөлж талбайд нэвтрэх орц гарцыг бүрэн хаасны дараа цэвэрлэгээ эхэлнэ.

**2. Ажиллагааны үед.**

2.1. Мөс цэвэрлэх машиныг зөвхөн оператор ажиллуулна.

2.2. Машины хурдыг 5–10 км/ц-аас хэтрүүлэхгүй.

2.3. Мөс цэвэрлэх явцад мөсөн талбайд оператораас өөр хүн байхыг хориглоно. Зайлшгүй шаардлагатай бол машинаас 5 метрийн зайд байна.

2.4. Яаралтай зогсолт хийх хийх үед "Яаралтай зогсолт" товчийг дарж машиныг бүрэн зогсоож хөдөлгүүрийг унтраана.

2.5. **Цэвэрлэгээний дараалал.**

- Спираль дамжуулагчийг асаах
- Ирний гүнийг тохируулах /Цэвэрлэх гүн 2 мм-ээс хэтрэхгүй байх/
- Усны урсгалыг нээх
- Тогтмол хурдаар жигд цэвэрлэх

2.6. Мөс чэвэрлэж дууссаны дараа Хөдөлгүүрийг унтрааж, машиныг угааж техникийн үзлэг хийнэ.

2.7. Мөс цэвэрлэх машин цэнэглэхдээ дараах дарааллыг дагаж мөрдөнө.

- Машины үндсэн тогийг салгаж бүрэн унтраана.
- Үндсэн болон цэнэглэгчийн пускатлыг унтраасан байна.
- Цэнэглэгчийг машинд залгасны дараа үндсэн пускатл өгнө.
- Үндсэн Пускатл өгсний дараа цэнэглэгчийн пускатл өгнө.
- Үндсэн болон цэнэглэгчийн пускатл өгсний дараа СТАРТ ногоон товч дарж цэнэглэнэ
- Машин бүрэн цэнэглэгдэж дууссаны дараа СТОП улаан товч дарж цэнэглэх ажиллагааг дуусгана.

**Анхааруулга: Хэт их хурд нь спираль дамжуулагчийг бөглөх шалтгаан болдог**

**3. Хориотой үйлдлүүд**

3.1. Согтууруулах ундаа хэрэглэсэн, ядарсан үед ажиллах

3.2. Техникийн гэмтэлтэй машин ажиллуулах

3.3. Аюулгүй байдлыг шалгалгүй ажил эхлэх /1.3, 1.5-д заасан/

## ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

- ~~Хурд: 15 км/ц~~
- Цахилгаан хангамж: 72V / 15кВт
- Жин: 3500 кг (хоосон), 4285 кг (ачаалагдсан)
- Мөс цэвэрлэх өргөн: 1950 мм

## ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ

**4. Өдөр тутмын шалгалт. Оператор нь машины эд ангид дараах шалгалтыг өдөр дутам хийнэ.**

4.1. Ирний (blade) хурц байдал, бэхэлгээг шалгах

4.2. Гидравлик систем дэх тосны түвшинг хянах

**5. Тогтмол засвар**

5.1. Ир солих: энгийн ирийг 25 цаг ажилласан бол. тусгай ган ирийг 60 цаг ажилласан бол солино.

5.2. Гидравлик тос солих: 2 сард нэг удаа шалгаж, 4 жил буюу 2000 цагт солино.

5.3. Тосолгоо үйлчилгээ, тохиргоог хавсралт №1-д заасан хугацаанд тогтмол хийж гүйцэтгэнэ.

5.4. Засвар үйлчилгээг зөвхөн техникч буюу мөс цэвэрлэгч машины оператор хариуцан хийнэ.

5.5. Оператор нь жил бүр хуваарьт засвар үйлчилгээтэй холбоотой зардал, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг гаргаж спорт хорооны дарга, нягтлан бодогчид танилцуулна. Гэнэтийн эвдрэл, гэмтэлтэй холбоотой зардлыг холбогдох албан тушаалтанд нэн дариу мэдэгдэж шийдвэрлүүлнэ.

## ГЭНЭТИЙН БУЮУ ЯАРАЛТАЙ НӨХЦӨЛД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

6.1. Мөс хагарах: Машиныг тэр даруй зогсоож, бүх хүмүүсийг холдуулна.

6.2. Цахилгааны гэмтэл: Засвар хийхээс өмнө цахилгаан хангамжийг салгах

## ХАДГАЛАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТ

7.1. Удаан хугацаагаар хадгалахдаа машиныг хуурай, сэрүүн орчинд байрлуулна.

7.2. Ир, цахилгаан хэсгүүдийг салгаж арчин даавуун материалаар боож хуурай газар хадгална

Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/49 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

RX4020 Мөс цэвэрлэх машины тосолгоо, тохиргоо үйлчилгээний хуваарь

| Д/Д | Зураг | Эд ангийн нэр | Тосолгоо хийх давтамж |
|---|---|---|---|
| 1 |  | Цасны хайрцгийн урд хойд тэнхлэгийн тулгуур /баруун, зүүн/ | 5 сар дутамд |
| 2 |  | Урд тэнхлэгийн баруун, зүүн дугуйны жолоодлогын тосолгооны цэг | 5 сар дутамд |
| 3 |  | Чиргүүлийн дүүжин тэнхлэгийн тулгуур (зүүн) | 5 сар дутамд |

| | | | |
|---|---|---|---|
| 4 |  | Чиргүүлийн дүүжин тэнхлэгийн тулгуур (баруун) | 5 сар дутамд |
| 5 |  | Босоо шнекийн дээд холхивч | 3 сар дутамд |
| 6 |  | Босоо шнекийн доод холхивч | 3 сар дутамд |
| 7 |  | Хутганы тулгуур холхивч | 5 сар дутамд |

<table>
<tr><td>8</td><td><br>
</td><td>Чиргүүлийн баруун талын шнекийн холхивч</td><td>3 сар дутамд</td></tr>
<tr><td>9</td><td></td><td>Чиргүүлийн зүүн талын шнекийн холхивч</td><td>3 сар дутамд</td></tr>
</table>

Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/49 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

## RX4020 Мөс цэвэрлэх машины тосолгоо, тохиргоо үйлчилгээний хуваарь

| Д/Д | Зураг | Эд ангийн нэр | Тосолгоо хийх давтамж |
|---|---|---|---|
| 1 |  | Цасны хайрцгийн урд хойд тэнхлэгийн тулгуур /баруун, зүүн/ | 5 сар дутамд |
| 2 |  | Урд тэнхлэгийн баруун, зүүн дугуйны жолоодлогын тосолгооны цэг | 5 сар дутамд |
| 3 |  | Чиргүүлийн дүүжин тэнхлэгийн тулгуур (зүүн) | 5 сар дутамд |

| | | | |
|---|---|---|---|
| 4 |  | Чиргүүлийн дүүжин тэнхлэгийн тулгуур (баруун) | 5 сар дутамд |
| 5 |  | Босоо шнекийн дээд холхивч | 3 сар дутамд |
| 6 |  | Босоо шнекийн доод холхивч | 3 сар дутамд |
| 7 |  | Хутганы тулгуур холхивч | 5 сар дутамд |

| | | | |
|---|---|---|---|
| 8 |    | Чиргүүлийн баруун талын шнекийн холхивч | 3 сар дутамд |
| 9 |  | Чиргүүлийн зүүн талын шнекийн холхивч | 3 сар дутамд |